



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 сарын 5-ны өдөр

То №1

Улаанбаатар хот

Төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг томилох тухай

Компанийн тухай хуулийн 78.1 заалт, “Монгол Базалт” ХК-ийн 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базалт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Лхагважав овогтой Ариунболд-ыг томилсугай.
2. Компанийн төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах, хурлыг зохион байгуулах, хурлыг даргалах, хяналт тавьж ажиллахыг үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:

Л. Ариунболд

Г. Ганзориг

Б.Шаравсамбуу

П. Сайнбилэг

Nan Gyu Bong

Ч.Зоригтбаатар

Т.Цэнд-Аюуш

Ш.Энхтөр

А. Энхгэрэл



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 сарын 5-ны өдөр

То №2


Улаанбаатар хот



Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороодын дарга, гишүүнийг томилох тухай


Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйл, “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:


1. “Монгол Базальт” ХК-ийн төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх аудитын хороо, нэр дэвшүүлэх хороо, цалин урамшууллын хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.
2. Аудитын хорооны даргаар Ч.Зоригтбаатар, гишүүдээр Т.Цэнд-Аюуш, Б.Шаравсамбуу нарыг тус тус томилсугай.
3. Нэр дэвшүүлэх хорооны даргаар Ш.Энхтөр, гишүүдээр Хан Гю Бунг, Т. Цэнд-Аюуш нарыг тус тус томилсугай.
4. Цалин урамшууллын хорооны даргаар Л. Ариунболд, гишүүдээр Ш. Энхтөр, Ч.Зоригтбаатар нарыг тус тус томилсугай.
5. Монгол Улсын компанийн тухай хууль, холбогдох дүрэм, журмыг хэрэгжүүлж ажиллахыг хороодын дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

ТУЗ-ИЙН ГИШҮҮҮД:


Л. Ариунболд

Г. Ганзориг

Б.Шаравсамбуу

П. Сайнбилэг

Han Gyu Bong

Ч.Зоригтбаатар

Т.Цэнд-Аюуш

Ш.Энхтөр

А. Энхгэрэл



“МОНГОЛ БАЗАЛЫТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 сарын 5-ны өдөр

То №3

Улаанбаатар хот

Журам батлах тухай

Компанийн тухай хуулийн 76.1.13, компанийн засаглалын кодексын хөтөлбөрийг хэрэгжүүлэх, “Монгол Базальт” ХК-ийн 2019 оны 6 дугаар сарын 5-ны өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журмыг хавсралт 1-р, ногдол ашгийн журмыг хавсралт 2-р, дотоод хяналтын үйл ажиллагааны журмыг 3-аар, мэдээллийн үйл ажиллагааны журмыг хавсралт-4 өөр тус тус баталсугай.
2. Батлагдсан журмын хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг Төлөөлөн удирдах зөвлөлөлийн нарийн бичгийн даргад даалгасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД



“МОНГОЛ БАЗАЛТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2019 оны 6 сарын 5-ний өдөр

То №5

Улаанбаатар хот

“Монгол Базальт” ХК ногдол ашиг хуваарилах, ногдол ашиг тараах хугацааг урагшлуулах тухай

Монгол Улсын компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1, 46.2, 46.5, 46.6, 46.8 заалтууд, 76 дугаар зүйлийн 76.1.12 заалт, “Монгол Базальт” ХК –ийн 2019 оны 6 дугаар сарын 5-ний өдрийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТОГТООХ НЬ:

1. “Монгол Базальт” ХК-ийн 2018 оны цэвэр ашгийн 86%-ийг хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хэлбэрээр хуваарилахаар шийдвэрлэж, нэгж хувьцаанд 3 төгрөг 30 мөнгө /гурван төгрөг гучин төгрөг/ -ний ногдол ашиг тараахаар тогтсугай.
2. Ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах өдрийг хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын бүртгэлийн өдөр байхаар тогтсугай.
3. “Монгол Базальт” ХК-ийн үүсгэн байгуулагч, компанийн нийт хувьцааны 70%-ийн хувьцааг эзэмшигч нэр бүхий таван (Л.Ариунболд, А.Энхгэрэл, П.Сайнбилэг, А.Энхжин, А. Энхмаа) хувьцаа эзэмшигчдээс ирүүлсэн хүсэлтийн дагуу тэдгээрийн ногдол ашгийг 2019 оны үйл ажиллагаа, хөрөнгө оруулалтанд зарцуулж, компани төлөвлөсөн хөрөнгө оруулалт хийж дуусгах хүртэл хугацаагаар ногдол ашгийг олгохыг хойшлуулахыг зөвшөөрсүгэй.
4. “Монгол Базальт” ХК-ийн 5 хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг өглөг үүсгэн нягтлан бодох бүртгэлд тусгахыг Ерөнхий нягтлан даалгасугай.
5. “Монгол Базальт” ХК-ийн дээрхи нэр бүхий таван хувьцаа эзэмшигчдээс бусад хувьцаа эзэмшигчдийн ногдол ашгийг ҮЦТХТ дэх дансанд 2019 оны 2 дугаар улиралд багтаан ҮЦТХТ-тэй гэрээ байгуулан ногдол ашгийг тараасугай.

ТУЗ-ИЙН ДАРГА



Л.АРИУНБОЛД